

БАТЛАВ.
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ОЮУНЧИМЭГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ, УЛС, ОРОН
НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ЗАВСРЫН АУДИТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сайнцагаан сум

2017 оны 09 дугаар сарын 05

- 1. Аудитын нэр:** Дундговь аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийх завсрын аудит
- 2. Үндэслэл:** Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын 1.9 дэх заалт, Дундговь аймаг дах төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв.
- 3. Зорилго, зорилт:** Санхүүгийн тайлангийн завсрын аудитын зорилго нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын бэлтгэл ажлын хүрээнд Дундговь аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ болон холбогдох хууль, заавар журмын дагуу үнэн, зөв бэлтгэгдсэн эсэх, байгууллагын дотоод хяналтыг үнэлэх, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, завсрын аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг аудитын явцад арилгуулах, харилцагч байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудад заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдэнэ.
- 4. Аудитаар хийгдэх ажлууд:**
 1. Хөрөнгийн үлдэгдэлд газар дээр нь биет тест хэрэгжүүлэх, үндсэн хөрөнгө, бараа материалд хэсэгчилсэн хяналтын тооллого хийх, зарцуулалтад давтан тооцоолол хийх, хөрөнгийг данс бүртгэлд бүрэн, үнэн, зөв тусгасан эсэхийг тулган шалгах.
 2. Санхүүжилт, орлого, зардлын гүйлгээг түүвэрлэн хууль, заавар журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгах, ажил гүйлгээг тулган баталгаажуулах, дүнгээс хөөн шалгах, давтан тооцоолол хийх;
 3. Өглөг, азлагын гүйлгээг дэлгэрэнгүй журнал, ерөнхий дэвтэртэй тулган шалгах, харилцагч байгууллагаас лавлагаа авч үлдэгдлийг тулган баталгаажуулах;
 4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт; /Аяны хүрээнд удирдамжийн дагуу/
- 5. Хамрах хүрээ, арга зүй:** Завсрын аудитад Дундговь аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын 2017 оны

эхний хагас жилийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл болон бусад холбогдох баримт материалыг бүрэн хамруулна.

6. Шалгуур: Завсрын аудит хийх зорилго, зорилттой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгоно. Үүнд:

1. Төсвийн байгууллагуудад мөрдөх санхүү болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, заавар журам, тогтоол, шийдвэрүүд / Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын баталсан журам, заавар, Дундговь аймгийн ИТХ-ын тогтоолууд, Засаг даргын захирамжууд ... гм /
2. Засгийн газрын 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 147 тоот тогтоол
3. УСНББОУС, СТОУС,НББОУС
4. Аудитын олон улсын стандарт
5. Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын журам, гарын авлага
6. Сангийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 22-ны 216 дугаар тушаал
7. Бусад

7. Хугацаа: Завсрын аудитыг 9 дугаар сарын 11-аас 12 дугаар сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэнэ.

8. Ажлын хөтөлбөр, хуваарь: Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөрийг Хавсралт №1, хуваарийг хавсралт №2, завсрын аудитаар гүйцэтгэх аудитын дэлгэрэнгүй горимыг хавсралт № 3-т тус тус харуулсан болно.

9. Завсрын аудит хийх багийн бүрэлдэхүүн

Завсрын аудитыг Дундговь аймаг дах төрийн газрын аудитын менежер хянан удирдаж, Санхүүгийн аудитын багийн ахлах аудитор болон аудиторууд батлагдсан хөтөлбөрийн дагуу тус тус гүйцэтгэнэ.

Төлөвлөгөө боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР



Т.БАТСАЙХАН